



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/208/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай сум
2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Оюунжаргал
Утас:99460422
Цахим хаяг: oyunjargald@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|-------------------------------------|
| 1. Аудитын санал дүгнэлт | Error! Bookmark not defined. |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 3 |
| 3. Аудитын тайлан | 6 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 6 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт..... | 6 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 6 |
| 3.4 Материаллаг байдал..... | 7 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 7 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 7 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 8 |
| 3.8 Аудитын гол асуудал..... | 8 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 8 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 9 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 9 |
| 4. Аудитын илрүүлэлт..... | 9 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл..... | 9 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2022.02.24 № 1302/246

танай _____ -ны № _____ -Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын ХЭДС-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын ХЭДС-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага


Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТУНДРАА

013025202

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|--|---------------------|---------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 2,106,508.13 | 2,326,437.35 |
| 33 | АВЛАГА | 2,106,508.13 | 2,326,437.35 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 2,520.00 | 9,835.00 |
| 335 | Бусад авлага | 2,103,988.13 | 2,316,602.35 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,103,988.13 | 2,316,602.35 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,106,508.13 | 2,326,437.35 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 271,798.50 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 271,798.50 | - |
| 413 | Өглөг | 271,798.50 | - |
| 4136 | Бусад өглөг | 271,798.50 | - |
| 41362 | Хөтөлбөрийн өглөг | 271,798.50 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,834,709.63 | 2,326,437.35 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,834,709.63 | 2,326,437.35 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,834,709.63 | 2,326,437.35 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,906,769.62 | 2,118,249.62 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (72,059.99) | 208,187.73 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,106,508.13 | 2,326,437.35 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 879,739.43 | 1,022,198.80 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 103,005.33 | 2,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 103,005.33 | 2,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 103,005.33 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 103,005.33 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 776,734.10 | 1,019,698.80 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 351,840.00 | - |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 351,840.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 424,894.10 | 1,019,698.80 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчиг бус этгээдээс авсан хандив, тусламж | 72,862.00 | 103,900.30 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 352,032.10 | 915,798.50 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 952,146.83 | 741,951.08 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 952,146.83 | 741,951.08 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,379.13 | 25,768.03 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 347.43 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 142.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4.43 | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 201.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,000.00 | 1,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,000.00 | 1,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,031.70 | 24,568.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,699.70 | 24,568.03 |
| 210902 | Хинээд үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,332.00 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 943,767.70 | 716,183.05 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 461,264.57 | 236,428.67 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 461,264.57 | 236,428.67 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 103,005.33 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 103,005.33 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 67,736.31 | 79,332.27 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 67,687.51 | - |
| 213405 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 48.80 | 79,332.27 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 311,761.49 | 400,422.10 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 311,761.49 | 400,422.10 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (72,407.40) | 280,247.72 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (72,407.40) | 280,247.72 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|-------------------|---|
| C01 | 2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,834,709.63 | 1,834,709.63 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,834,709.63 | 1,834,709.63 |
| C08 | 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,834,709.63 | 1,834,709.63 |
| D01 | 2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,834,709.63 | 1,834,709.63 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 211,480.00 | 211,480.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,118,249.62 | 2,118,249.62 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 280,247.72 | 280,247.72 |
| D09 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,398,497.34 | 2,398,497.34 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,183,414.06 | 1,022,198.80 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 406,679.96 | 2,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 406,679.96 | 2,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 406,679.96 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 303,674.63 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 103,005.33 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 776,734.10 | 1,019,698.80 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 351,840.00 | - |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 351,840.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 424,894.10 | 1,019,698.80 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 72,862.00 | 103,900.30 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 352,032.10 | 915,798.50 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,183,414.06 | 1,369,584.58 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,183,414.06 | 1,369,584.58 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,031.70 | 25,768.03 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,000.00 | 1,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,000.00 | 1,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,031.70 | 24,568.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,699.70 | 24,568.03 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,332.00 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,175,382.36 | 1,343,816.55 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 699,966.07 | 854,227.17 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 699,966.07 | 854,227.17 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 103,005.33 | 7,335.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 103,005.33 | 7,335.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 68,736.33 | 79,332.27 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 68,687.51 | - |
| 213405 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 48.82 | 79,332.27 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 303,674.63 | 402,922.10 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 303,674.63 | 402,922.10 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | (0.00) | (347,385.78) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (0.00) | - |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|--------|--|-----------------------|-----------|-----------------------|------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | - | - | 347,385.80 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | - | - | 347,385.80 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | - | - | 347,385.80 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | - | - | 347,385.80 |
| 213101 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | | | 347,385.80 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | - | - | 347,385.80 |
| 14 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | - | - | - | 347,385.80 |
| 145005 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | | | | 347,385.80 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|------------|--|----------|-------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 911,798.50 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 911,798.50 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 25,768.03 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 1,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 24,568.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 24,568.03 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 746,326.87 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 746,326.87 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 746,326.87 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 139,703.60 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 60,371.33 |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 79,332.27 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 911,798.50 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 911,798.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 911,798.50 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгаагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд ХЭДС-аас авсан зээлийн хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Д.Оюунжаргал, ахлах аудитор Г.Заяа нар гүйцэтгэж, хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Тус сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 217 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

ХЭДС нь Халамжаас Хөдөлмөрт -Халамж хүртэгчдийг хөдөлмөр эрхлэлтрүү чиглүүлж хандалгыг нь өөрчлөх орлоготой болгох, амжиргааг дээшлүүлэх гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Сангийн орлого, зардал нь илүү ач холбогдолтой тул нийт зардлыг материаллаг байдлын сууриар сонгов. Эрсдэл дунд гэж таамаглан хувь хэмжээг 1 хувиар авав.

Дунд эрсдэлтэй тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар тооцлоо.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 1022,1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 10,2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|----------------|-----------------|------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Нийт авлага | 2,106,508.1 | 2,326,437.3 | 219,929.2 |
| - Хөтөлбөртэй холбоотой авлага | 2,103,988.1 | 2,316,602.3 | 212,614.2 |
| - Татаас санхүүжилтийн авлага | 2,520.0 | 9,835.0 | 7,315.0 |
| Нийт хөрөнгө | 2,106,508.1 | 2,326,437.3 | 219,929.2 |
| - Өглөг | 271,798.5 | 0,00 | -271,798.1 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,834,709.6 | 2,326,437.3 | 491,727,7 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 2,106,508.1 | 2,326,437.3 | 219,929.2 |

Авлага дансны үлдэгдэл 219,929.2 мянган төгрөгөөр өссөн нь хөтөлбөртэй холбоотой авлага байна.

2020 онд 271,798.5 мянган төгрөгний өглөг үүссэнийг барагдуулан ажилласан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 491,727,7 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,053,343,0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,053,343.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр ХЭДС-аас 915,798,5 мянган төгрөгийн санхүүжилт, Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа орон нутгийн онцлогт тохирсон ХЭ-ийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөрийн санхүүжилт 103,900.3 мянган төгрөгийг тус тус авч үйл ажиллагааг хэрэгжүүлэн, эргэн төлөлтөөс 347,385,7 мянган төгрөгийг барагдуулан ажилласан байна.

Тайлант онд 1,022,198,8 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 347,385.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

-

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны ХЭДС-ийн авлага 2,316,602.3 мянган төгрөгийн 568,311.4 мянган төгрөг буюу 24,5 хувь нь гэрээт хугацаандаа төлөгдөөгүй зээлийн авлага байна. Үүний 161 иргэнтэй холбоотой 292,985.6 мянган төгрөгийн зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажилласан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Төсөл хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлт гэрээт хугацаандаа бүрэн төлөгдөхгүй байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсөл хөтөлбөрүүдийн эргэн төлөлт

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар гэрээт хугацаандаа төлөгдөөгүй 568,311,4 мянган төгрөгийн зээлийн авлагын барагдуулалтыг илрүүлэн ажиллаа.

4.1 Залруулсан алдаа

байхгүй

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сангийн нийт авдагын 568,311,421 төгрөг буюу 24,5 хувь нь гэрээт хугацаандаа төлөгдөөгүй төсөл хөтөлбөрийн эргэн төлөл байна. Үүнээс 161 иргэнтэй холбоотой 292,985.6 мянган төгрөгийн зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажиллаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Гэрээний хугацаанд барагдаагүй авлагыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулж хэрэгжилтийг албан тоотоор ирүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|-------------------------------------|----------------------|-------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1. | ХЭДС | 1 | 568,3 | | | | | | | 1 | 568,3 |